

“ИТДБ” төслийн магистр, докторын хөтөлбөрт хамрагдах багш, судлаачдад тавигдах шаардлага

1. Магистрын сургалтын хөтөлбөр:

Суралцах хугацаа: Япон Улсад - 2 жил хүртэл

Хамрах хүрээ:

а/ Инженер, технологи, байгалийн ухааны чиглэлээр МУИС болон ШУТИС-д ажиллаж буй эрдэм шинжилгээний ажилтан болон магистрын зэрэггүй багш нар;

б/ МУИС болон ШУТИС-д инженер, технологи, байгалийн ухааны чиглэлээр тэргүүлэх чиглэлийн судалгааны сэдвээр эрдэм шинжилгээ, судалгааны ажилд хамтран ажиллаж буй багш, судлаачид болон эрдэм шинжилгээний ажилтан;

Тавигдах шаардлага:

1. Монгол Улсын иргэн байх, 35 нас хүртэл;
2. Монгол Улсын магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургууль болон гадаадын их, дээд сургуулийг инженер, технологи, байгалийн ухааны чиглэлээр суралцаж төгссөн байх;
3. Гадаад хэлний шалгалт: Япон хэлний түвшин тогтоох JLPT шалгалтын N2 түвшин, эсвэл Англи хэлний TOEIC-600, TOEFL IBT-64, IELTS-5.0 шалгалтын оноо ба түүнээс дээш байх;
4. Японы их сургуульд элсэн суралцах болзол хангаж, суралцах урилга хүлээн авсан байх;
5. Сургууль /ажлын газар/ нь магистрын хөтөлбөрт суралцахыг дэмжсэн байх;
6. Сургуулиа төгсөж ирэхэд ажлын байраар хангах баталгаа гаргасан байх;
7. Суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх гэрээ болон уг гэрээний хавсралт болох үл хөдлөх хөрөнгийн барьцааны гэрээний нөхцөлийг зөвшөөрсөн байх;

2. Докторын сургалтын хөтөлбөр:

Суралцах хугацаа: Япон Улсад - 3 жил хүртэл

Хамрах хүрээ:

а/ Инженер, технологи, байгалийн ухааны чиглэлээр МУИС болон ШУТИС-д ажиллаж буй эрдэм шинжилгээний ажилтан, докторын зэрэггүй багш нар;

б/ МУИС болон ШУТИС-д инженер, технологи, байгалийн ухааны чиглэлээр тэргүүлэх чиглэлийн судалгааны сэдвээр эрдэм шинжилгээ, судалгааны ажилд хамтран ажиллаж буй багш, судлаачид, болон эрдэм шинжилгээний ажилтан;

Тавигдах шаардлага:

1. Монгол Улсын иргэн байх, 40 нас хүртэл;
2. МУИС болон ШУТИС-д инженер, технологи, байгалийн ухааны чиглэлээр ажиллаж буй багш, ажилтан

3. Монгол Улсын магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургууль болон гадаадын их, дээд сургуулийг инженер, технологи, байгалийн ухааны чиглэлээр суралцаж төгссөн байх;
4. Гадаад хэлний шалгалт: Япон хэлний түвшин тогтоох JLPT шалгалтын N2 түвшин, эсвэл Англи хэлний TOIEC-600, TOEFL IBT-64, IELTS-5.0 шалгалтын оноо ба түүнээс дээш байх;
5. Японы их, дээд сургуулиудад элсэн суралцах болзол хангаж, суралцах урилга хүлээн авсан байх;
6. Сургууль /ажлын газар/ нь докторын хөтөлбөрт суралцахыг дэмжсэн байх;
7. Сургуулиа төгсөж ирэхэд ажлын байраар хангах баталгаа гаргасан байх;
8. Суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх гэрээ болон уг гэрээний хавсралт болох үл хөдлөх хөрөнгийн барьцааны гэрээний нөхцөлийг зөвшөөрсөн байх;

Дээрх шаардлагыг хангасан нэр дэвшигчдийн бүрдүүлэх материалын жагсаалт

1. Анкет; /маягтын дагуу/
2. Иргэний үнэмлэхийн хуулбар;
3. Бакалавр /магистр/-ын дипломын нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;
4. Япон, эсвэл Англи хэлний түвшин тогтоох шалгалт өгсөн батламжийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар /Сүүлийн 2 жилд өгсөн байх/;
5. Япон талын их, дээд сургуулиас ирүүлсэн суралцах эрхийн бичиг;
6. Сургуулийн /ажлын газрын/ тодорхойлолт, Ажлын байраар хангах тухай;
7. Эрдэм шинжилгээний бүтээлийн жагсаалт;
8. Судалгааны ажлыг удирдаж буй хоёр талын их сургуулийн профессорын тодорхойлолт;
9. Судалгааны ажлын төлөвлөгөө;
10. Сургуулиа төгсөөд эх орондоо мэргэжлээрээ хэрхэн ажиллах тухайгаа Монгол-Англи, эсвэл Монгол-Япон хэл дээр бичсэн 700-800 үгтэй эссэ;
11. Суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх гэрээ, уг гэрээний хавсралт болох үл хөдлөх хөрөнгийн барьцааны гэрээний нөхцөлийг зөвшөөрсний үндсэн дээр элсэхийг хүссэн өргөдөл /Маягт харгалзахгүй/;
12. 3x4 хэмжээтэй 2 хувь цээж зураг /Сүүлийн 3 сард авахуулсан байх/;

Бүртгэлийг хаах хугацаа 2018 оны 1-р сарын 25-ны өдөр хүртэл
Онлайн бүртгэлийн холбоос (Монголоор):

<https://goo.gl/forms/dLF159FHz769y6yV2>

(Англиар) <https://goo.gl/forms/8iZ5bvH0z8qdEAjv1>